

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 01 дүгээр
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2015 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 67 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагаас энэ онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/122 дугаар тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөх эрх бүхий орон тооны бус зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2015 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталж, 25 удаа хуралдаж, удирдлага, зохион байгуулалтын 28, хүний нөөцийн 22, албаны шалгалтын дүнгийн тухай 61 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцож, шийдвэрийн талаарх мэдээллийг төв, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэст хүргүүлж, алба хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан.

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын даргаас удирдлага зохион байгуулалтын /А тушаал/ 130, хүний нөөцийн /Б тушаал/ 665, тэргүүн дэд даргаас 94 тушаал тус тус батлагдан гарч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жишиг нормативын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/75, 141 дүгээр тушаалаар Говь-Алтай, Дундговь аймаг дахь цагдаагийн хэлтсийг төсөв, орон тоонд нь багтаан “Цагдаагийн газар” болгосон.

Хууль зүйн сайдаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай, Цагдаагийн ерөнхий газрын даргаас албад, харьяа газар, хэлтсийн дарга нартай Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 онд байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг Хууль зүйн яамнаас 94.6 хувь буюу “Бүрэн хангалттай” гэж дүгнэсэн.

Хууль зүйн сайдын 2015 оны “Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/89 дүгээр тушаалыг баталж, цагдаагийн төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын алба хаагчдын томилолтыг үе шаттайгаар зохин байгуулж ажилласан.

Үүнд: ЦЕГ-ын даргын 2015 оны Б/251-р тушаалаар Эрүүгийн цагдаагийн газар, Мөрдөн байцаах газар, Б/252-р тушаалаар Замын цагдаагийн газар, Б/253-р тушаалаар Сургалтын төв, Б/276-р тушаалаар Судалгаа, дүн шинжилгээний төв, Б/278-р тушаалаар Төмөр зам, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Б/285-р тушаалаар Холбооны хэлтэс, Мэдээлэл технологийн төв, Б/288-р тушаалаар Хэвлэл мэдээллийн төв, Лицензийн төв, Б/294-р тушаалаар Тусгай ажиллагааны газар, Б/324-р тушаалаар Хамгаалалтын 1, 2, 3-р газар, Төв архив, Сүүж-Уул сувилал, Авто бааз, Олон нийт, хамтын ажиллагааны төв, Хангалт, үйлчилгээний төв, Б/284-р тушаалаар Улаанбаатар хотын цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтэц, орон тоог, Б/279-р тушаалаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын бүтцийг тус тус баталж мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн талаарх мэдээллийг Улсын ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, УЕП-ын туслах, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс, УДШ, ШШГЕГ, ТЕГ, ХСИС, ТагЕГ, ТахЕГ, АТГ, ТЕГ, МХЕГ, ХХЕГ, ИНЕГ зэрэг 14 газарт хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрүү, Мөрдөн байцаах, Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий нэгжүүдийн мөрдөн байцаалт явуулах хэргийн харьяаллыг шинэчлэн тогтоох санал, танилцуулгыг Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын шуурхай хуралдаан 2015 онд 6 удаа хуралдаж, Цагдаагийн ерөнхий газарт 15 үүрэг, даалгавар өгсөн. Үүрэг, даалгаварыг хэрэгжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулж, биелэлтийг тогтоосон хугацаанд Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Хууль зүйн сайдаас аймаг, нийслэлийн засаг даргатай 2016 онд хамтран ажиллах гэрээнд тусгуулах саналыг бэлтгэж ЦЕГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/562 дугаар албан бичгээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн, 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажлын чиглэлээр анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг тус тус оролцож, санал бодлоо солилцсон.

Хууль зүйн яамны 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Архидан согтуурахтай тэмцэх сангийн болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах саналыг тус тус бэлтгэн, Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын дотоод аудитын жилийн болон дунд хугацааны стратеги, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын жилийн төлөвлөгөө, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт, Улсын Их хурал, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын төсөв, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилт, Хууль зүйн сайдын өгсөн үүрэг, даалгаврын биелэлт болон холбогдох бусад хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажилд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 7 заалт бүхий зөвлөмжийг 2015 оны 4/448 дугаар албан бичгээр төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажилласан ба Засгийн газрын нэгдсэн цахим хуудасны 5 дэд цэсний 18 ангилалд мэдээлэл байршуулахаас Цагдаагийн ерөнхий газрын харьяа 55 газар, хэлтэс 10 ангилалд 373 мэдээлэл, өөрийн байгууллагын цахим хуудсанд төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой 53 төрлийн 925 мэдээллийг байршуулсан.

“Хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээ”-ний удирдамжийн дагуу 2015 оны 09 дүгээр сарын 07-14-ний өдрүүдэд Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд мэдээлж сурталчлах, чиг үүргийнхээ дагуу иргэдэд тодорхой үйлчилгээ үзүүлэх, санал хүсэлтийг авах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулсан.

Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газрын хамт олноос санаачилсан уриалгыг дэмжиж, Монгол хүний эрүүл мэнд, амь насыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт үед нь илрүүлэх, эмчлэх сайн үйлсэд зориулан алба хаагчдаас 7.4 сая төгрөгийг Хавдар судлалын үндэсний төвд хандивласан.

Албан үүргээ үнэнч шударгаар гүйцэтгэж яваад амь насаа алдсан алба хаагчдаа эргэн дурсаж, “Бид мартаггүй өдөрлөг”-ийг 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр цагдаагийн байгууллагын Төв музейд зохион байгуулж, тэдний гэр бүл, үр хүүхэд, эцэг, эхэд нь хүндэтгэл үзүүлсэн.

Монгол Улсад генерал цол бий болсны 71 жилийн ой, “Генералуудын өдөр”-ийн арга хэмжээг 2015 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр, Цагдаагийн байгууллагын түүхт 94 жилийн баяр, “Цагдаагийн алба хаагчдын өдөр”-ийг 07 дугаар сарын 19-ний өдөр, “Монголын

ахмадын өдөр”-ийг 09 дүгээр сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулж, цагдаагийн газрын ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

“Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт 2015 оны 09 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд хамрагдаж, 96.6 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Монголын дүлий иргэдийн үндэсний холбоо, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар зэрэг байгууллагуудтай “Хамтран ажиллах санамж бичиг”, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, Төрийн орон сууцны корпарацитай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Мэдээлэл, технологи, шуудан, харилцаа холбооны газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, зардал багатай хүргэх “Цахим болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвөөс үзүүлж буй тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авч мэргэжлийн үнэмлэх олгох, жолоодох эрх сэргээх, үнэмлэх нөхөн олгох, жолоочийн үнэмлэх солих, гадаадын иргэнд жолооны үнэмлэх сольж олгох, жолоочийн лавлагаа гэсэн 6 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, Мэдээлэл, технологийн паркад нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан. Иргэд ТҮЦ машинаас төрийн үйлчилгээнд нэвтрэх түлхүүр үг авч, www.ezasag.mn сайтаар дээрх үйлчилгээнүүдийг авах боломжтой болсон.

Лицензийн төвөөс “Хатан Эрдэнэ” төрийн бус байгууллагатай хамтран “Тэгш зам” төслийг хэрэгжүүлэх “Хамтран ажиллах тухай” гэрээ байгуулж, 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсний улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, зөрчлийн бүртгэлийн оноо дууссан жолооч нарт сургалт зохион байгуулах, замын хөдөлгөөний хууль дүрмийн цахим шалгалт авах иж бүрэн 40 компьютер, бусад техник хэрэгслийг нийлүүлэн цахим шалгалт авах танхимыг байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Шударга ёсны төлөө-2015” уралдааны “Ил тод, нээлттэй цахим хуудастай байгууллага” номинацид Цагдаагийн ерөнхий газар нь иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн ажиллагааг цахимжуулах, иргэдийн хяналт, оролцоог идэвхжүүлэх зорилгоор www.smartpolice.mn цахим үйлчилгээг нэвтрүүлж, 2015 оноос www.service.police.gov.mn болгон өргөжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж чадсан байгууллагаар шалгарсан.

Цагдаагийн ерөнхий газрын Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны төвийн “Монгол онгод” хамтлаг “Авъяаслаг Монголчууд” тэмцээний шилдэг 32-т шалгарч амжилттай оролцсон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Итали улсын Дотоод явдлын яамны урилгаар тус улсын цагдаагийн байгууллагатай хамтын ажиллагааны талаар уулзалт хийх, үйл ажиллагаатай нь танилцах, туршлага судлах зорилгоор 2016 оны 01 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд БНИУ-д албан томилолтоор ажилласан.

Цагдаагийн байгууллагын харъяа нэгж, албадаас 2015 онд санаачлан хэрэгжүүлсэн 404 /давхардсан тоогоор/ шинэлэг ажил, тэргүүн туршлагыг судлан үзээд нийт нэгжүүдэд түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэх боломжтой гэж үзсэн 159 ажлыг сонгон авч нэгтгэн боловсруулж “Төв, орон нутгийн цагдаагийн нэгжүүдийн хэрэгжүүлсэн шинэлэг ажил, тэргүүн туршлага” гарын авлага номыг бэлтгэн гаргасан.

Уг гарын авлагад удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 44, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 52, алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сайжруулах чиглэлээр 32, ажиллах нөхцлийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 31 тэргүүн туршлага ажил арга хэмжээг тусгасан.

“Цагдаагийн байгууллагын хамгаалалтад авах онц чухал объектын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, танилцуулгыг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлснээр Засгийн газрын 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 19, мөн оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 118 дугаар тогтоолоор тус тус нэмэлт оруулж батлуулсан.

Зөрчлийн тухай, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх

тухай, Хохирлын сангийн, Цагдаагийн албаны тухай, Прокурорын байгууллагын тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай, Өмгөөллийн тухай, Дотоодын цэргийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Казиногийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Гүйцэтгэх ажлын тухай, Галт зэвсгийн тухай, Тагнуулын албаны тухай, Мөрдөх албаны тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын төслүүд болон шинэчилсэн найруулгын төсөлд санал бэлтгэж, Хууль зүйн яаманд тус тус хүргүүлсэн.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг дагаж гарах 9, Галт зэвсгийн тухай хуулийг дагаж гарах 16 дүрэм, журам, стандарт, зааврын төсөл танилцуулгыг тус тус боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлэн батлуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/72 дугаар тушаалаар “Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтын заавар”, А/73 дугаар тушаалаар “Борлуулагчийн галт зэвсгийн бүртгэлийн загвар”, “Борлуулагчийн сумны бүртгэлийн загвар”, А/74 дүгээр тушаалаар “Галт зэвсгийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Сум Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Гадаадын иргэн Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Тамирчид Монгол Улсын хилээр галт зэвсэг нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, “Галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрлийн загвар”, А/75 дугаар тушаалаар “Галт зэвсгийн гэрчилгээний загвар”, “Галт зэвсгийн гэрчилгээ олгох журам”-ыг тус тус батлуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/321, 231 дүгээр тушаалаар “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ыг батлуулсан.

Цагдаагийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 856 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын жагсаалт, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг боловсруулах загвар”-ыг шинэчлэн баталсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь 9 бүлэг, 256 журмаас бүрдэх бөгөөд 2015 оны байдлаар 9 бүлэг, 253 журмыг буюу 98.8 хувийг шинэчлэн баталж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн, цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ /system.police.gov/-нд байршуулсан бөгөөд журмын санг шинэчлэн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын захиргааны хэм хэмжээ тогтоосон 8 шийдвэрийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн.

УИХ болон Хууль зүйн байнгын хорооны “Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн ажлын хэсэгт, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай болон холбогдох бусад хуулийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт Хуулийн хэлтсийн дарга ажиллаж, дүнг нэгтгэн, Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн бөгөөд УИХ-ын чуулганаар “Эрүүгийн хууль”, “Зөрчлийн тухай хууль”-ийг батлуулсан.

Цагдаагийн ерөнхий газартай холбогдуулан нэхэмжлэл гаргасан иргэн, Ц.Алтан-Эрдэнэ, Ц.Баясгалан, Г.Баттөр, Б.Ванчинсүрэн, Т.Оюунбаатар, Ж.Буянбат, О.Энхтуяа, Л.Нямжав, Т.Мөнхгэрэл, Ш.Цогтбаатар, Т.Өлзийхутаг, Т.Амарсанаа, Ц.Цэрэнчимэг, Ж.Нарантунгалаг, Б.Саруулбат нарын нэхэмжлэлтэй иргэний болон захиргааны 44 хэрэгт оролцсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын нэгдүгээр газар, Өмнөговь, Булган, Орхон, Хөвсгөл, Увс, Баянхонгор, Дундговь аймаг дахь цагдаагийн газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, Архангай, Тусгай ажиллагааны газар, Мэдээлэл, технологийн төв, Сургалтын төв, Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, Дорноговь аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэст хэсэгчилсэн, Улаанбаатар хотын Замын цагдаагийн газар, “Цагаан шонхор” төрийн өмчит үйлдвэрийн газар, Дархан-Уул аймгийн цагдаагийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт явуулж, хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч нар 347хоног томилолтоор ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2015 онд зохион байгуулсан 8 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын ажлын

бүрэлдэхүүнд Аюулгүй байдал, төрийн нууц, шифр харилцааны хэлтсийн аюулгүй байдал хариуцсан ахлах байцаагч нар томилогдон ажилласан байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар 2 тэрбум 856.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 207.8 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан.

Дотоод хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар 39 танилцуулга бичиж, цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.

Шалгалтын мөрөөр ажлын байрны зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлсэн, цагдаагийн алба хаагчийн ёс зүйг зөрчсөн 40 алба хаагчид Төрийн албаны тухай хуулийг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, эрсдэлийг бууруулах чиглэлээр 39 зөвлөмж, 24 үүрэг, ажлын чиглэл, 6 албан даалгавар хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын А/80 дугаар тушаалаар “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх” ажлын хэсгийг байгуулж, “Эс Ай Си Эй” ХХК-ийг сонгон шалгаруулан гэрээ байгуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 11, алба хаагчийн чиглэлээр 7, нийт 18 үзүүлэлтээр хэрэглэгчдээс санал асуулга авч, үнэлгээ хийлгэн, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн индексг тооцолсон байна. Судалгаанд Улаанбаатар хот, Ховд, Өвөрхангай, Хэнтий аймгаас сонгогдсон 519 иргэн хамрагдсан. Иргэдээс Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий үнэлгээ 4.01, байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ 4.06, алба хаагчдын үнэлгээ 3.93 гэж үнэлэгдсэн байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах, бэлэн байгаа хүний нөөцийг үнэлэх, хэрэгцээг тодорхойлох, түүнд учирч болох эрсдэлийг тооцоолох, чадварлаг, тогтвор суурьшилтай боловсон хүчин бий болгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/164 дүгээр тушаалаар “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Цагдаагийн байгууллагын сургалтын бодлогын баримт бичиг”-ийг тус тус баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт осол гэмтэл, хэрэг, зөрчлийн хор холбогдлыг таниулах чиглэлийн тусгайлсан 4 төрлийн хичээлийн сэдвийг тусгуулахаар Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт хичээлийн цаг, сэдвийг хүргүүлэн хамтран ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын хүний нөөцийн холбогдолтой 247 тушаалаар 13597 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнээс бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 8600, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 536, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 111, офицер, дадлагажих ажилтнаар томилогдсон 57, шинээр газар, хэлтэс, тасгийн даргаар томилогдсон 97, нөөцөөс 22, Хууль сахиулахын их сургууль, ОХУ, Туркийн сургуулийн төгсөгч 218, эргүүлэн томилсон 21, хөдөлмөрийн гэрээгээр 9, ТЗ энгийн 9, албан тушаал дэвшүүлэн томилсон 317, хүүхэд асрах чөлөө цуцалсан 57, түдгэлзүүлснийг цуцалсан 1, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн 16, цуцалсан 3, албан тушаал бууруулан томилсон 85 алба хаагчийн тушаалыг тус тус гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр өөрийн хүсэлтээр 93, өөр албанд 23, гачигдлаар 1, эмнэлгийн магадлагаагаар 5, сургуульд суралцуулахаар 12, чөлөөлсөн 27, хүүхэд асрах чөлөөгөөр 76, тэтгэвэрт гаргахаар 40 алба хаагчийг ажлаас чөлөөлж, данс бүртгэлээс 9 алба хаагчийг хасч, дутагдлаар 54 алба хаагчийг албанаас халсан байна.

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан алба хаагчдаас төрийн одон медалиар 92, Хууль зүйн яамны шагналаар 67, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 110, “Хүндэт жуух бичиг”-ээр 213, “Баярын бичиг”-ээр 82, “Спортын алдар” тэмдгээр 13, “Цагдаагийн төлөө тэмдэг”-ээр 33, Дотоодын цэргийн алдар тэмдгээр 25, “Албаны төлөө-I” медалиар 23, “Албаны төлөө-II” медалиар 22, “Албаны төлөө-III” медалиар 23 алба хаагчийг шагнаж, урамшуулан, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 54 алба хаагчийг албанаас дутагдлаар халж, 17 алба хаагчид сануулж, 18 алба хаагчийн албан тушаалын цолыг хураан, цагдаагаар ажиллуулж, 117 алба хаагчийн цолны нэмэгдэл, сарын цалинг тодорхой хувиар бууруулах сахилгын шийтгэл ноогдуулсан.

Тасгийн дарга, түүнээс дээш албан тушаалд томилогдох 514 алба хаагчийн 3084 хуудас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэн хүлээн авч, Авилгатай тэмцэх газарт хүргүүлж, хариуг авч ажилласан.

Хууль зүйн сайдын 2015 оны “Журам батлах тухай” А/64 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж албан тушаалын цол хэрэглэж байсан цагдаагийн хурандаа 11, цагдаагийн дэд хурандаа 41, цагдаагийн хошууч 139, цагдаагийн ахмад 844, нийт 1035 алба хаагчийн цолыг хурааж, урьд хэрэглэж байсан цагдаагийн хурандаа 19, цагдаагийн дэд хурандаа 113, цагдаагийн хошууч 187, цагдаагийн ахмад 65, цагдаагийн ахлах дэслэгч 18, нийт 402 алба хаагчийн цолыг сэргээн олгож, хугацааны цагдаагийн хурандаа 9, дэд хурандаа 40, хошууч 80, ахмад 77, ахлах дэслэгч 93, дэслэгч 103 алба хаагчид цол олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Алба хаагчид албаны үнэмлэх, энгэрийн тэмдэг олгох, хураан авах журам /код 916/-д заасны дагуу төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсээс ирүүлсэн материалыг хүлээн авч нэгдсэн солилцоор 9240 алба хаагчдад үнэмлэх шинэчилэн олгосон.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 916.2.6-д заасны дагуу цагдаагийн “А” зэрэглэлийн үнэмлэх гээгдүүлсэн 115 алба хаагчид 1.150.000 энгэрийн тэмдэг гээсэн 74 алба хаагчид 1.110.000 албаны үнэмлэхээ санамсар болгоомжгүйн улмаас угааж гэмтээсэн 19 алба хаагчийн үнэмлэхийг хураан авч 57.000, нийт 2.317.000 төгрөгийн нөхөн төлбөр төлүүлж, албаны шалгалт явуулж, арга хэмжээ авагдсан тушаалын хуулбар болон бусад шаардлагатай материалыг үндэслэн журмын дагуу олгож ажилласан.

2015 онд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 1825 өргөдөл, гомдол хүлээн авчшалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 265 нэгж буюу 16.9 хувиар өсч, 1959 алба хаагч холбогдсоны 1411 буюу 72.0 хувь нь офицер, 533 буюу 27.2 хувь нь ахлагч, 15 буюу 0.8 хувь нь энгийн бүрэлдэхүүн байна. Нийт өргөдөл гомдлын 1772 буюу 97.1 хувийг барагдуулж, 53 буюу 2.9 хувийн үлдэгдэлтэй байна.

Нийт зөрчлийг төрлөөр нь авч үзвэл: 167 буюу 9.2 хувь нь хууль ёс, хүний эрх чөлөөг зөрчсөн, 101 буюу 5.5 хувь нь хэрэг материал дутуу шалгасан, 15 буюу 0.8 хувь нь хэргийн хугацаа хэтэрсэн, 50 буюу 2.7 хувь нь бусдыг чирэгдүүлж танил тал харсан, 494 буюу 27.1 хувь нь цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн, 17 буюу 0.9 хувь нь хээл хахууль шан харамж авсан, 136 буюу 7.5 хувь нь бусдыг зодож эрх чөлөөнд нь халдсан, 292 буюу 16.0 хувь нь ажлын хариуцлага алдсан, 82 буюу 4.5 хувь нь архидан согтуурсан, 4 буюу 0.2 хувь нь өмч хөрөнгө үрэгдүүлсэн, 463 буюу 25.4 хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль дүрэм зөрчсөн, 2 буюу 0.1 хувь нь цалин, тэтгэвэр тэтгэмж буруу тогтоосон, 2 буюу 0.1 хувь нь төсвийн хөрөнгө ашигласан зөрчлүүд эзэлж байна.

Сахилгын арга хэмжээ авагдсан байдлыг авч үзвэл: Эрүүгийн хэрэг үүсгэхээр шилжүүлсэн 51, албанаас халсан 73, цол бууруулсан 5, цалин бууруулсан 387, сануулсан 179, алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нотлогдоогүй 1135, нотлогдсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан 48 байна.

2015 оны байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 328 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 158 буюу 48.2 хувь нь санал хүсэлт, 128 буюу 39.2 хувь нь гомдол, 22 буюу 6.7 хувь нь талархал, 17 буюу 5.2 хувь нь шүүмжлэл, 3 буюу 0.9 хувь нь өргөдөл байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 328 буюу 89.6 хувийг шийдвэрлэж, 34 буюу 10.4 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 216 буюу 66.5 хувийг 5 хоногийн дотор, 75 буюу 23.1 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийн талаар:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, 2015 онд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Цагдаагийн байгууллагад иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн дуудлага, мэдээллийг хүлээн авах, дамжуулах, дуудлагын мөрөөр очсон цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, иргэдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгох зорилгоор “Дуудлага, мэдээллийн хяналт, үнэлгээний хуудас”-ны загвар маягыг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 920 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх

гомдол, мэдээлэл хүлээн авах журам” /код 202/-ыг батлуулж, цагдаагийн газар, хэлтсүүдэд хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, холбоо, төрийн бус байгууллагуудын зүгээс зохион байгуулагдах жагсаал цуглаан, бусад хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр удирдлагыг мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, жагсаал, цуглааны нөхцөл байдалд анализ, дүн шинжилгээ хийж ажилласан.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх, хадгалах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн дагуу Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Шивээ овоо” ХХК-ий зөөврийн үйлдвэр, Дорнод аймгийн Матад суманд үйл ажиллагаа явуулж буй “Спэйк” ХХК-ий туслан гүйцэтгэгч “Пауэр пласт” ХХК-ий тэсрэх бодисын үйлдвэр агуулахад Мэргэжлийн хяналт, Тагнуул, Онцгой байдлын ерөнхий газар, Уул уурхайн яамтай хамтарсан шалгалт хийсэн.

Засгийн газраас Монгол Улсад эрүүгийн хэрэгт шалгагдаж буй гадаадын иргэдийн асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авч, явцын талаар тухай бүр танилцуулж, дүнг олон нийтэд мэдээлж байхыг Хууль зүй, Гадаад хэргийн сайд нарт даалгасны дагуу холбогдох мэдээллийг нэгтгэн танилцуулгыг боловсруулж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 3 жилд бүртгэгдсэн “Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгсэл”-тэй холбоотой гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар танилцуулга бэлтгэн, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн.

Баянгол, Баянзүрх дүүргүүдэд “Саун, массажист” нэрээр охид, эмэгтэйчүүдийг биеэ үнэлэхэд татан оролцуулж, зохион байгуулалттайгаар биеийг нь үнэлүүлж байж болзошгүй саун, массажийн газруудыг төлөвлөгөөний дагуу шалгаж, орон байраар хангасан 7 газрын үйлдлийг баримтжуулан эрүүгийн хариуцлагад татаж, биеэ үнэлж байсан 23 охид, эмэгтэйчүүдийг олж тогтоон, бүртгэл судалгаанд хамруулж, Захиргааны хариуцлагын тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн дагуу 8 эмэгтэйд баривчлуулах арга хэмжээ авсан.

Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд олон улсын мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ эрхлэгч Улаанбаатар, Хаан, Голомт, Кредит, Хас, Худалдаа хөгжил, Капитал, Төрийн банкны удирлагуудтай уулзалт хийж, Western, Union, Moneygram, Swift зэрэг үйлчилгээнд ашиглагдах шилжүүлгийн маягтуудад санамж, сэрэмжлүүлэг бүхий нэмэлт хуудас байршуулах ажлыг эхлүүлсэн.

“Илрүүлэлт-Оргодол” нэгдсэн арга хэмжээг 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд гурван үе шаттайгаар зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй эрүүгийн хэрэг 487, түдгэлзүүлсэн 174, нийт 661 гэмт хэргийг илрүүлж, Эрэн сурвалжлах мэдээллийн “ASAP” сангаар гэмт хэрэгт сэрдэгдэн эрэн сурвалжлагдаж байсан болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр эрэн сурвалжлагдаж байсан 324 оргодлыг баривчлан эрэн сурвалжлалтыг зогсоосон байна.

Дуудлага, мэдээлэл өгсөн иргэн бүртгэлийн болон регистрийн дугаараар цагдаагийн байгууллагын www.service.police.gov.mn цахим хуудсанд хандаж өөрийн гаргасан өргөдөл, гомдлыг шалгаж байгаа цагдаагийн газар, хэлтэс болон шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг харах боломжтой болсон. Мөн дуудлага өгсөн иргэдийн гар утсанд “SMS-MT” буюу мессеж хэлбэрээр мэдээлэл хүргэх тусгай дугаарын үйлчилгээг шинээр нэвтрүүлэхээр төлөвлөн, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орчиндоо түгшүүр төрүүлдэг, байнга архи дан согтуурч, гэр бүлдээ хүчирхийлэл, дарамт учруулдаг иргэдийн зан үйлийг өөрчлөх зорилгоор Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран “Хүчирхийлэл үгүй гэр бүлд таны оролцоо” сэдэвт 6 цагийн сургалтыг 2015 оны 03 дугаар сард зохион байгуулж, 180 иргэнийг хамруулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2015 оны эхний хагас жилийн тайланг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдээс авч нэгтгэн 2 дугаар хагас жилд ажиллах ажлын чиглэл хүргүүлсэн.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн яамнаас 2015 оны 7 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг”-т “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон хуулийн төсөлд цагдаагийн байгууллагын хүлээх үүрэг” сэдвээр мэдээлэл, “Дэлхийн зөн-Монгол” олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах “Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт сургалтад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, анхаарах асуудал” сэдвээр энэ оны 9 дүгээр сард сургалт зохион байгуулж ажилласан.

Гадаадын иргэдийн гэмт хэрэгт өртөж, хохирсон, холбогдсон нөхцөл байдлын талаарх мэдээллийг сар бүр Хууль зүйн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Хар тамхи, мансууруулах бодис, хүн худалдаалах, үндсэрхэг үзэлтэй байгууллага, иргэний, тэсэрч дэлбэлэх бодис, хуурамч мөнгөн дэвсгэртийн талаарх эхний 6 сарын нөхцөл байдлын талаарх танилцуулгыг боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлж ажилласан.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, таслан зогсоох зорилгоор Монгол Улсын цагдаагийн байгууллага, БНХАУ-ын НАХЯ, ӨМӨЗО-ны Дотоодыг хамгаалах тэнхимтэй хамтран БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод 2015 оны 11 дүгээр сарын 16 наас 11 дүгээр сарын 18 ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Хяналтын дор хүргүүлэх” сэдэвт хамтарсан дадлага-сургалтад ЦЕГ-ын даргын Б/561 дугаарын тушаалаар ЭЦГ-ын дэд даргаар ахлуулсан Улаанбаатар хотын цагдаагийн газар, дүүрэг, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дэд дарга нарын нийлсэн 16 алба хаагч, тус газраас 8 алба хаагч нийт 25 алба хаагч оролцсон.

Тус арга хэмжээний хүрээнд хоёр улсын хилээр хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар нэвтрүүлж байгаа зохион байгуулалттай бүлэг этгээдүүдэд дундын баримтжуулалтыг зохион явуулж дайчлан баривчилж байгаа тухай сургалтын киног хамтран бүтээсэн.

Монгол Улсын Хууль Зүйн Сайдын 2015 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3-т орсон “Мансууруулах үйлчилгээтэй ургамлын тархац тогтоогдсон аймгийн нутаг дэвсгэрт ургаж буй ургамлыг устгах” ажлыг 3 дахь жилдээ хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу Төв, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Хэнтий, Дорнод аймгийн хогийн олсны ургамал /каннабис/-ын тархац тогтоогдсон, 2013, 2014 онуудад устгал хийгдсэн нутаг дэвсгэрийг хамруулан 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 15 хоногийн хугацаанд “Устгал 2015” арга хэмжээг зохион явуулсан.

Улсын хэмжээнд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хүн амины хэрэг, эрэн сурвалжлагдаж буй оргодол, сураггүй алга болсон хүний талаарх мэдээллийг нэгтгэн “Гэмт хэргийн лавлагаа 3” номын эхийг бэлтгэсэн. Мөн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл бичих, схем зураг үйлдэх ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор нийтлэг үйлдэгддэг 16 төрлийн хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл, схем зургийг мэргэжлийн түвшинд жишиг загвар боловсруулан ном болгон гаргахаар МБГ, ЭЦГ, Улаанбаатар хотын цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсүүдтэй хамтран ажиллаж байна.

“Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг оролцуулан “Цахим тоглоом” сургалтыг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт тус тус зохион байгуулж, нийт 264 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалахад ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Улсын ерөнхий прокурорын газартай хамтран ЦЕГ-ын удирдлага, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн дарга, мөрдөн байцаах тасгийн дарга нарыг биечлэн, аймгуудын цагдаагийн газар, хэлтсийн дарга, хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгийн дарга нарыг аймгийн прокурорын газарт цахим хэлбэрээр оролцуулан цахим хурал, уулзалтыг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр УЕПГ-т зохион явуулж, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд учирч буй хүндрэл бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх, прокурорын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр: 2015 онд улсын хэмжээнд 1423088 захиргааны зөрчлийг бүртгэж, 1372058 иргэн, 37 албан тушаалтан, 1172 аж, ахуйн нэгж байгууллага нийт 17016347,1 /17 тэрбум/ төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан 97560 хүнийг саатуулж, 339 хүнийг албадан эмчилгээнд хамруулан, 503 хүнийг сайн дурын эмчилгээнд, 13174 хүнийг шүүхээр баривчлуулан, 287 гэмт этгээдийг олж тогтоон холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж цагдаагийн байгууллагаас гүйцэтгэж байсан иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг нь бүртгэлийн байгууллагад шилжсэн тул Улаанбаатар хотын цагдаагийн газарт байсан 2005-2015 оны 161 хадгаламжийн нэгж бүхий 54897 хуудас материалыг 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсийн 36 хадгаламжийн нэгж бүхий 3887 хуудас материалыг 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдөр тухайн аймаг дахь бүртгэлийн газруудад хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Хүн ам, орон сууцны завсрын тооллого явагдаж байгаатай холбогдуулан, Үндэсний статистикийн хорооны мэргэжилтнүүдтэй уулзаж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд тэргүүн дэд даргын 2/259 дугаартай албан бичгээр ажлын чиглэл өгч, “Судалгаа, хяналтын мэдээллийн сан”-д авагдсан 1021 тэнэмэл иргэний мэдээллийг 6/4661 дугаартай албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хүргүүлж, тооллогын ажлын хэсгийн 1, 2 дугаар хуралдаанд оролцож, тэнэмэл /орон гэргүй/ иргэдийн тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулахтай холбоотой шаардагдах 5165.864 төгрөгийн төсвийн тооцоог батлуулж, зохион байгуулсан.

Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан “Өршөөл үзүүлэх тухай хууль” батлагдсантай холбогдуулан, салбар төлөвлөгөө гарган, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж, ЦЕГ-ын Шуурхай удирдлагын штаб, ШШГЕГ-ын штаб, хорих 401, 407, 411, 431 дүгээр ангиудад батлагдсан хуваарийн дагуу алба хаагчдаас 3 хоног ажиллаж, удирдлагыг мэдээллээр ханган, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийг ажлын чиглэлээр хангаж ажилласан.

Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран “Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ял нь тэнсэгдсэн, шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээдэд тавьж байгаа хяналтыг сайжруулах” сэдэвт зөвлөгөөнийг 2015 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Улаанбаатар хотын цагдаагийн газрын даргын зөвлөлийн 3 дугаар хуралдаанаар “Нийслэл хотод үйлдэгдсэн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга замын талаар” сонсгол, мэдээлэл хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан шийдвэрийг Нийслэлийн удирдлагын зөвлөлд танилцуулан, Монгол Улсын Засгийн газрын 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо, автомашины хангалт, гүйлтийн жишиг норматив”-ын дагуу эргүүлийн 20 цэгт 20 автомашин авах, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг газруудад 200 ширхэг телекамер байршуулах нийт 1.600.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд “School police” эргүүлийн үйл ажиллагааг дэмжих талаар санал хүргүүлж, 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.

Орон нутгийн замд хурд хэмжигч камерыг байнгын постын байршилтай уялдуулах, интернетийн сүлжээгээр хангах асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Мянганы хөгжлийн сорилтын сангийн санхүүжилтээр хийгдсэн TAIS /Traffic Accident Information Sistem/ програмыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сантай уялдуулах, ашиглалтад хүлээн авах, үйл ажиллагаанд нэвтрүүлэх, Засгийн газрын 2004 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

2015 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр “Чингисийн талбай”-д “Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнтэй хамтран Улсын Их хурлын Тамгын газар, Хууль зүйн яам, Зам тээврийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийгмийн эрүүл мэндийн газар, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Монголын улаан загалмайн нийгэмлэг, Замын аюулгүй байдлын үндэсний төв зэрэг

шийдвэрлэх түвшний байгууллагуудыг оролцуулсан “Нөлөөллийн уулзалт”-ыг зохион байгуулж, оролцогчдоос мэдээлэл, танилцуулга, илтгэл тавьж зам, тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх, ослыг бууруулах, хэрэгжүүлэх шаардлагатай байгаа ажлын талаар санал бодлоо солилцсон.

Уг үйл ажиллагаанд Хууль сахиулахын их сургуулийн 270, Батлан хамгаалахын их сургуулийн 300, Төмөр замын дээд сургуулийн 200 оюутан, Монголын иргэдийн холбоо, жолооч бэлтгэх сургалтын төвүүдийн багш нар, явган зорчигч зэрэг нийт 2000 гаруй оролцогч Амарын гудамжнаас Чингисийн талбай хүртэл хохирогсдын дуу хоолойг илэрхийлсэн зурагт самбар, уриа, үг, зурагт санамж, “Уусан бол бүү жолоод” хоёр төрлийн 1000 ширхэг зурагт санамж, сэрэмжлүүлгийг барьж жагсан, зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэхийг олон нийтэд уриалсан.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор нийт 38859 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж зааварчилга өгч ажилласнаас тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг 1700, банк, банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх 5910, үйлчилгээний 22446, их дээд 618, ерөнхий боловсролын 3250 сургууль, цахим тоглоомын 1416 газар, асрамж халамжийн 151 төв, бусад 7871 аж ахуйн нэгж, байгууллага байна. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 16556 мэдэгдэл, шаардлага, зөвлөмж өгч 15552 хариуг хүлээн авсан.

Мөн алба хаагчид нийт 1052708 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 1733688 зөрчил илрүүлсэн.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10606 удаагийн яриа, сэрэмжлүүлгийг давхардсан тоогоор 181492 хүнд хүргэж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй интернэт, цахим тоглоомын газруудад нэгдсэн шалгалт зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан.

“Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан болон хорих ял нь тэнсэгдсэн этгээдэд тавих хяналтыг сайжруулах 45 хоногийн хамтарсан аян”-ы төслийг Улсын ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэстэй хамтран боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий прокурорын орлогчоор батлуулан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу “Согтууруулах ундааны хяналтын тухай хууль”-ийн төслийг сурталчлах зорилгоор согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн статистик дүн мэдээ, насанд хүрээгүй хүнээс архидан согтуурч буй зөрчлийн талаар “Босго Фильм” студтэй хамтран захиалгат нэвтрүүлэг бүтээж, олон нийтэд хүргэсэн.

Шинээр 1416 галт зэвсэг бүртгэж, 249 зөвшөөрөл олгож, 718 нуугдмал галт зэвсгийг илрүүлж, зөрчлийн учир 980 галт зэвсгийг хураан авч, 186 иргэн, 1 байгууллага, 1 албан тушаалтанд 2083.0 мянган төгрөгийн захиргааны арга хэмжээ авсан.

Иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомж зөрчсөний улмаас хураагдсан 960 галт зэвсэг, 36584 ширхэг сумыг устгах, худалдах, шилжүүлэх дүгнэлт гаргуулахаар шинжилгээнд хүргүүлж, шинжилгээнд тэнцээгүйг устгах, тэнцсэнг үнэлгээ хийлгэж худалдан борлуулах бэлтгэл ажлыг хангаж, сумдад нэгдсэн үзлэг шалгалт хийж ажилласан.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас 2015 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг “Тамхины хууль бус худалдаалалттай тэмцье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах албаны дарга нарын баталсан удирдамжийн дагуу 05 дугаар сарын 27-ны өдөр нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд хамтарсан шалгалт зохион байгуулж, цагдаагийн байгууллагаас Тамхины хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын талаарх мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэсэн.

Нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг захиргааны нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1473 эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр 279, гэр бүлийн

хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1006, бусад 622 нийт 3380 санал хүргүүлж шийдвэрлүүлсэн байна.

Олон нийтийн цагдаагийн ажилтны үйл ажиллагааг сурталчилсан 3300 ширхэг зурагт хуудас хэвлүүлж, сурталчлах ажлыг зохион байгуулсан бөгөөд улсын хэмжээнд давхардсан тоогоор 3303 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж, 2259 зөрчлийг илрүүлж, 1203 иргэнийг 380000 төгрөгөөр торгосон.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Иргэний зөвлөл, олон нийтийн цагдаагийн ажилтнуудын хамтарсан анхдугаар зөвлөгөөнийг 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, олон нийтийн цагдаагийн ажилтнуудын жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг үнэлж дүгнэн, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэн, санал, хүсэлтийг сонсон, идэвх санаачилгатай, бусдыгаа манлайлан ажилласан олон нийтийн цагдаагийн 8 ажилтныг шагнаж урамшуулсан.

Байгалийн гамшигт байдал үүсч замын нөхцөл байдал хүндэрсэн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хаах, хязгаарлах журмын төслийг Онцгой байдлын ерөнхий газар, Авто тээврийн үндэсний төв, Авто замын хөгжлийн төв, Ус цаг уур, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлсэн.

Улаанбаатар хотод 2015 оны 09 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохиогдсон Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын Парламентын ассамблейн намрын ээлжит хурал хуралдах үед хэв журмын хамгаалалтыг зохион байгуулж, хариуцуулсан ажлыг бүрэн хангаж ажилласан.

Хууль зүйн сайдын 2015 оны А/77 дугаар тушаалаар батлагдсан “Архидан согтуурахтай тэмцэх сангийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн саатуулах байранд хяналтын камер суурилуулах чиглэлээр 25 байгууллагаас саатуулах байрны план зургийг авч, саатуулах байр тус бүр дээр тавигдах техник, хэрэгслийн судалгааг гаргаж, хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын даргын баталсан “Цагдаагийн байгууллагын албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хийх хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Хүний эрхийн үндэсний комисстой хамтран дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиг, үүрэг бүхий алба хаагчидтай уулзалт, фокус ярилцлага, санал асуулга авах ажлыг зохион байгуулсан.

Хуулийг нэг мөр хэрэглэх, алба хаагчдын ажил, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий алба хаагчдын албан хэрэгцээнд зориулан “Эргүүлийн үйл ажиллагаанд анхаарвал зохих асуудал”-ын талаарх “Зөвлөмж-2” эмхтгэл, гарын авлагыг боловсруулан, 5000 ширхэгийг хэвлүүлж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлсэн.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын ассамблейн /OSCE-PA/-н намрын ээлжит хурал зохион байгуулагдах үеийн цагдаагийн хамгаалалтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий 14 ажлын хэсэг томилон, хамгаалалтын үйл ажиллагааг 2015 оны 09 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт орж, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн төв байр, эфир, Монгол банкны орон нутаг дахь хэлтэс, салбарын харуул, хамгаалалтыг цагдаагийн хамгаалалтад авсантай холбогдуулан объектод ажиллах алба хаагчдыг томилон ажиллуулж байна.

Монгол Улсад айлчилж байгаа гадаад орны төр, засгийн тэргүүн, зочин төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтыг гүйцэтгэх, зохион байгуулах ажлыг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

“Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын хамгаалалтад тавигдах шаардлага” байгууллагын стандартыг баталсан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/11 дүгээр тушаалын хуулбарыг Стандартчилал, хэмжил зүйн газарт 76/1976 дугаар албан бичгээр хүргүүлж бүртгүүлсэн.

Бүгд Найрамдах Солонгос Улсын ерөнхий сайд, Эрхэмсэг ноён Хван Гё Аны, БНХАУ-ын Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн Их хурлын байнгын хорооны дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Иоахим Гаук, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Цэргийн төв комиссын гишүүн, Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Чан Ванцюй тэргүүтэй

төлөөлөгчид, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын Ассемблейн намрын хурал, Оросын Холбооны Улсын Холбооны хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкин, БНЧУ-ын Праламентын танхимын төлөөлөгчдийн дарга, Ян Хамачек, БНСУ-ын Ерөнхийлөгч асан Ли Мён Бак, БНКУ-ын Ерөнхийлөгч асан Р.Отунбаева, Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхийлөгч Янош Адер, гэргий Хээрцэг Анита, Бүгд Найрамдах Болгар Улсын Ерөнхийлөгч Росен Плевнелиев, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхий сайд Нарендра Модди, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Гадаад хэргийн сайд Вунна Маун Лвин болон тус Улсын Ерөнхийлөгч нарын манай улсад албан ёсны айлчлал хийх үеийн аюулгүй байдлыг хангах хамгаалалт, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 94 жилийн ой, Арвандолдугаар жарны модон хонь жилийн сар шинийн баяр, Дорноговь аймгийн Айраг суманд "Айргийн хурд", Баян-Өлгий аймгийн төв Өлгий сумын "Улаан толгой" гэх газарт "Наурыз"-ын баярт, Төв аймгийн Баяндэлгэр суманд сумын уяачдын холбооноос Шүдлэн, Хязаалан насны, Ховд аймгийн төв Ховд суманд хурдан морины "Хаврын бүс", Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 33 дугаар тогтоолд заасны дагуу Хурдан морины "Дүнжингарав-2015" Төвийн бүсийн хаврын уралдаан зэрэг нийт 2305 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 56603 цагдаагийн алба хаагч, 6390 автомашин, 27756 тусгай хэрэгсэлтэйгээр 164647 цагийн үүрэг гүйцэтгэсэн.

Үүнээс Улаанбаатар хотод 1144 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 39269, хөдөө орон нутагт 1161 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 17334 алба хаагч тус тус үүргээ хуулийн хүрээнд хэвийн гүйцэтгэсэн байна.

Хамгаалалтыг төрлөөр нь авч үзвэл: Улсын хэмжээнд Үндэсний их баяр наадам болон аймаг, сумын баяр наадмын 315 удаагийн хамгаалалтад 5287, улс, бүсийн даншиг наадам, хурдан морины уралдааны 167 удаагийн хамгаалалтад 6617, урлаг спортын арга хэмжээний 462 удаагийн хамгаалалтад 7654, төрийн тусгай хамгаалалт болон гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлалын үеийн 862 удаагийн хамгаалалтад 28833, бусад төрлийн 499 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд давхардсан тоогоор 8212 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж ажилласан.

Зохион байгуулагдсан нийтийг хамарсан 16 удаагийн арга хэмжээний хамгаалалтад тус албанаас 21 төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь, 163 зураглалыг боловсруулж төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хамгаалалттай холбоотой 49 удаагийн ажлын чиглэл хүргүүлж, үр дүнг тухай бүр тооцож ажилласан.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаан, нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээлэлтэй танилцаж, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт /шифр 78 удаа/ ажлын чиглэл хүргүүлж, холбогдох алба хаагч нартай нөхцөл байдлын талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцож ажилласан.

2015 онд дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн объектуудад 1561548 хүн, 370216 тээврийн хэрэгсэл, 51858 вагон нүүрс, экспортод 185271 уут 8483 чингэлэг зэсийн баяжмал, 1362 уут 125 чингэлэг молибдений баяжмал, лабораторид шинжлүүлэх 13909.7 кг зэсийн баяжмал, 1602.7 кг молибдений баяжмал, тэсрэх бодисын үйлдвэрээс 10727.9 тонн тэсрэх бодисыг шалган нэвтрүүлж, 385650 хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж, хамгаалалтын бүсэд харуулын цагдаагийн хяналт, шалгалтаар 365 зөрчлийг илрүүлэн шалгаж, 25 иргэнийг байгууллагын захиргаанд мэдэгдэж, согтуу байсан 6 иргэнийг саатуулах байранд хүргүүлж, захиргааны зөрчил үйлдсэн 334 иргэнийг "Захиргааны хариуцлагын тухай хууль"-ийн холбогдох заалтын дагуу 1.670.000 төгрөгөөр торгох арга хэмжээг авч, захиргааны хэргийн туслах тоо бүртгэлийн санд бүртгэсэн байна.

Мөн 2015 онд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг 25 аж ахуйн нэгжтэй байгуулсан "Тээвэрлэлтийн хамгаалалтын гэрээ"-ний дагуу нийт 580 удаагийн хамгаалалтыг зохион байгуулж, 8561 тонн 141 кг тэсэрч дэлбэрэх бодис, 3865409 метр, 3062825 ширхэг тэсэлгээний хэрэгслийг 19 аймгийн 41 сумын нутаг дэвсгэрт байрладаг агуулахад тээвэрлэн хүргэх ажиллагааг Хамгаалалтын гуравдугаар газрын 4 дүгээр хэсгийн давхардсан тоогоор 598 алба хаагчийн хүчээр, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэстэй хамтран гүйцэтгэж, удирдлага-хяналтаар хангаж ажилласан.

2015 онд мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин 19 аймгийн 81 сумын нутагт давхардсан тоогоор нийтдээ 205 удаа гарч, 1961 толгой мал, амьтан өвчилж, 933 толгой мал, амьтан хорогдсон байна. Тухайн бүс нутагт хорио цээрийн дэглэмийг тогтоох үеэр төв, орон нутгийн цагдаагийн байгууллагаас Цагдаагийн албаны тухай хуулийн 11

дүгээр зүйлийн 11.1.2-т заасан: "...хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэмийг сахиулах" чиг үүргийг хэрэгжүүлж, Онцгой байдал, мэргэжлийн хяналт болон бусад төрийн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, давхардсан тоогоор цагдаагийн 8186 алба хаагч хамтран ажилласан.

Баян-Өлгий, Говь Алтай, Ховд аймагт малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан дээрх 3 аймгийн 15 суманд цагдаагийн дэд хурандаа Ж.Амгалан Улсын онцгой комиссын гишүүдтэй газар дээр нь очиж танилцан, ажлын чиглэл өгч албан томилолтоор ажиллаа.

Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 3 дугаар тушаалаар "Газар хөдлөлтийн гамшгийн нэгдсэн төлөвлөгөө шинэчилсэн боловсруулах ажлын хэсэг"-т 2015 оны 10 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд, ОБЕГ-ын даргын 2015 оны 11 сарын 24-ны А/311 тушаалаар батлагдсан Булган аймгийн 9 сумдад Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдлын үзлэг шалгалт хийх ажлын хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 29-өөс 12 дугаар сарын 04-ний өдрүүдэд ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Ж.Амгалан ажилласан.

Цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, өвөлжилт хүндэрсэн болон хүндэрч болзошгүй зарим аймгуудын Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албадад цаг үеийн асуудлаар мэргэжлийн заавар зөвлөгөө, үүрэг чиглэл өгөх, гамшгийн эрсдлийн үнэлгээ хийх үүрэг бүхий Улсын Онцгой комиссын даргын 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 08 дугаар тушаалаар байгуулагдсан "Шуурхай бүлэг"-т алба хаагч нар 2 ажлын хэсэгт хуваагдан 10 хоногийн хугацаатай Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан Хөвсгөл, Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Төв аймгуудад тус тус ажилласан.

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний тавдугаар ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд сонгон шалгаруулалтад тэнцсэн цагдаагийн 28 алба хаагчийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2015 оны А/174 дүгээр тушаалаар Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд 2015 оны 05 дугаар сараас ажиллагааны өмнөх бэлтгэлд хамруулж, мөн оны 08 дугаар сард энхийг сахиулах үүрэг гүйцэтгэхээр явсан.

Гурав. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллага 2015 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 475434 гомдол, мэдээлэл хүлээн авсны 96661 буюу 20.3 хувь нь гэмт хэргийн, 115236 буюу 24.0 хувь нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байсныг шалгаж шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд 27757 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 439 хэргээр буюу 1.6, нийслэлд 734 хэргээр буюу 4.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн 64.7 хувь нь нийслэлд, 35.2 хувь нь аймгуудад, 0.1 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 48.6 хувийг хөнгөн, 43.7 хувийг хүндэвтэр, 5.9 хувийг хүнд, 1.8 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 0.7 хувийг хүнийг санаатай алах, 1.0 хувийг хүчиндэх, 0.8 хувийг булаах, 1.2 хувийг завших, үрэгдүүлэх, 1.9 хувийг дээрэмдэх, 5.0 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.7 хувийг танхайрах, 7.4 хувийг залилан мэхлэх, 29.1 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 33.0 хувийг хулгайлах, 14.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 13922 гэмт хэрэг бүртгэгдэж, түүнээс 8644 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 62.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.5 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 58.9 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.5 нэгжээр өссөн байна.

Улсын хэмжээнд хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 64.1, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 58.9, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 72.9, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 91.9 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас 113 аж ахуйн нэгж, байгууллага, 27948 иргэдэд 144.3 тэр бум төгрөгийн хохирол учирснаас 49.0 тэр бум төгрөг буюу 33.9 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оноос 4.6 хувиар өссөн, 38.9 тэр бум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас 847 хүн нас барж, 11287 хүн гэмтсэн нь урьд оны мөн үеэс нас барсан хүн 231 буюу 21.4 хувиар буурч, гэмтсэн хүн 6 буюу 0.1 хувиар өссөн байна.

Гэмт хэрэгт 24857 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 4.7 хувиар өсч, нийт шалгагдсан хүний 15.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оныхоос 4.5, 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оныхоос 12.2 хувиар өссөн байна.

Насны ангиллаар авч үзвэл, 15 хүртэлх насны 419, 16-17 насны 983, 18-24 насны 5768, 25-29 насны 5323, 30-34 насны 3997, 35-39 насны 3040, 40-44 насны 2194, 45-49 насны 1435, 50-54 насны 982, 55-59 насны 461, 60-64 насны 155, 65-69 насны 58, 70 ба түүнээс дээш насны 42 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Нийт 1423088 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 741866 зөрчлөөр буюу 2.0 дахин өссөн байна.

Зөрчил гаргасан 1372058 иргэн, 37 албан тушаалтан, 1172 аж ахуйн нэгж, байгууллагад 17.0 тэрбум төгрөгөөр торгох, 26166 иргэнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасах, 13174 иргэнд баривчлах, 10440 иргэнд торгож эрх хасах, 40 иргэнд торгож баривчлах, 1 иргэнд эрх хасч, баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Захиргааны зөрчлийн 271288 буюу 19.1 хувь нь аймгуудад, 1151800 буюу 80.9 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар 67363 иргэн, 10 албан тушаалтан, 394 аж ахуйн нэгж, байгууллагад 1154571.5 мянган төгрөгөөр торгох, 26161 иргэнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 13126 иргэнд шүүхээр баривчлах; Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 19177 иргэн, 22 аж ахуйн нэгж байгууллагад 4926982.2 мянган төгрөгөөр торгох, 10440 иргэнд торгож, эрх хасах, 40 иргэнд торгож, баривчлах, 1 иргэнд баривчилж, эрх хасах; Жолоочийн даатгалтын тухай хуулиар 1054 иргэнд 202393.5 мянган төгрөгөөр торгох, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 519 иргэн, 1 албан тушаалтанд 25682.0 мянган төгрөгөөр торгох, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 1351 иргэн, 6 албан тушаалтан, 725 аж ахуйн нэгж, байгууллагад 252040.0 мянга, Тамхины хяналтын тухай хуулиар 2235 иргэн, 12 байгууллага, аж ахуйн нэгжид 117722.0 мянга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 135 иргэн, 18 албан тушаалтан, 17 аж ахуйн нэгж, байгууллагад 5375.0 мянга, Галт зэвсгийн тухай хуулиар 231 иргэн, 2 албантушаалтан, 1 аж ахуйн нэгжид 5201.0 мянган төгрөгөөр торгох, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар 8 иргэнд 400.0 мянган төгрөгөөр торгох, 36 иргэнийг баривчлах, бусад хууль тогтоомжоор 122 иргэнд 15041.2 мянган төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 97560 хүн саатуулагдсанаас 59042 буюу 60.5 хувь нь Улаанбаатарт, 38518 буюу 39.5 хувь нь орон нутагт, тэдний 5442 буюу 5.6 хувь нь эмэгтэй, 387 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Дөрөв. Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны талаар:

Мэдээллийн сан, технологийн чиглэлээр: “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ”, “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны хэргийн болон түдгэлзүүлсэн хэргийн хөдөлгөөн шийдвэрлэлтийн мэдээ”-г нэгтгэн гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн ба дээрх мэдээнүүдийг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээний system.police.gov болон Хууль зүйн яамны салбарын статистикийн мэдээллийн сангийн, Үндэсний Статистикийн хорооны medee@nso.mn цахим хуудаст тус тус байршуулж мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын хэмжээнд 2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, зарим тодорхой төрлийн гэмт хэрэг, түүний үйлдэгдсэн онцлог, захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл, шалтгаан нөхцөл, хүчин зүйл, урьдчилан сэргийлэх арга зам гэсэн үндсэн сэдвүүд, мөн зарим тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалсан судалгааны ажлын танилцуулга, тайлан, илтгэл, зөвлөмжийг багтаасан “Монгол Улс дахь 2014 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт товхимлыг бэлтгэн хэвлүүлж холбогдох дээд шатны байгууллага болон хууль сахиулах байгууллагууд, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.

Гомдол, мэдээллийн санд 475434 мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн 470632, гэмт хэргийн 30439 мэдээлэл, хохирогч иргэн, байгууллагын 32847, хохирлын 23635, хохирол нөхөн төлүүлэлтийн 11457, битүүмжилсэн хөрөнгийн 1235, сэжигтний 21091, яллагдагчийн 20080, таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон 12391, яллагдагчаар татах тогтоол батлуулах, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 9624,

хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлсэн 15744, нэгтгэсэн 2270, түдгэлзүүлсэн 8013, сэргээсэн хэргийн 8427, нөхөн илрүүлсэн хэргийн 1201, хэрэг, бүртгэлт мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн 898, прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан 2780, зүйлчлэл өөрчилсөн 1613, харьяаллын дагуу шилжүүлсэн 1261 мэдээллээр баяжилт хийсэн.

Захиргааны зөрчлийн мэдээллийн санд торгуулийн хуудсаар шийдвэрлэгдсэн 1279774, шийтгэврээр 93493, эрх хассан 26166, баривчилсан 13214, хохирсон иргэний 5608 мэдээлэл бүртгэгдсэн.

Захиргааны тоо бүртгэлийн мэдээллийн санд согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган саатуулагдсан 97560, захиргааны хяналтад байгаа 3672, албадан эмчилгээнд хамруулсан 339, захиргааны журмаар түр болон албадан саатуулагдсан 959 иргэний мэдээлэл бүртгэгдсэн.

Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангаас нийт 122 байгууллага, албан тушаалтанд гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар 214 судалгаа, 58 танилцуулга, мэдээлэл бэлтгэн хүргүүлж, 2262 байгууллага, иргэнд албан бичгээр 63440, тодорхойлолтоор 65594 лавлагаа мэдээлэл гарган хүргүүлсэн.

Ял шийтгэлтэй эсэх лавлагааг тодорхойлолт авах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 11496, визэнд орох, гадаадад оршин суугаа иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 24183 хүнийг шалгаж хариу өгсөн.

Түүнчлэн Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 600, харьяат болох хүсэлт гаргасан 382 хүний ял шийтгэлтэй эсэхийг шалгаж, хариуг өгсөн.

Ялтны хувийн хэргээс хуулбар авах хүсэлт гаргасан 1612 албан бичгийн дагуу 2894 хувийн хэргээс давхардсан тоогоор 20624 хуудас материалыг хуулбарлан өгсөн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан 2350 ялтны хувийн хэрэг, ялтны судалгааны карт ирүүлснийг хянан, бүртгэлд авч дугаар олгож архивт байршуулсан ба тойргийн шүүхүүдээс ирүүлсэн 7281 ширхэг ял шийтгэлийн тэмдэглэлийг санд оруулжээ.

Галт зэвсгийн програм хангамжийг галт зэвсэг бүртгэх маягтын дагуу өөрчилж gun.police.gov хаяг дээр байршуулж, шинээр 421 галт зэвсгийн загварыг бүртгэсэн.

Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс цагдаагийн байгууллагад хандаж гаргасан дуудлага, мэдээллийг цахим хэлбэрээр авах, цагдаагийн байгууллагын үйлчилгээг ил тод болгох, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Цагдаагийн байгууллагын цахим үйлчилгээ” /service.police.gov.mn/цахим хуудсыг боловсруулсан. Цахим хуудсаар дамжуулж иргэн өөрийн гаргасан гомдол, мэдээллийг аль цагдаагийн газар, хэлтсийн ямар албан тушаалтан шалгаж байгаа, тухайн гомдол, мэдээлэл хэрхэн шийдвэрлэгдсэн талаар мэдээллийг авах бүрэн боломжтой болсон.

Гомдол, мэдээлэл хүлээн авсан талаарх мэдээлэл, бүртгэлийн дугаарыг иргэдийн гар утсанд мессэж хэлбэрээр хүргэх “SMS-MT” үйлчилгээ шинээр нэвтрүүлэхэд шаардагдах 20 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэн, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийнтөв, үүрэнтелефоныоператор /Mobicom, Skytel, Unitel, G-Mobile/ компаниудтайхамтран ажиллах гэрээ байгуулж, UB Police 131102 тусгай дугаар ашиглан, гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авсан талаарх мессэжийг текст хэлбэрээр иргэдийн гар утсанд илгээх ажиллагааг 2015 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтын чиглэлээр: Цагдаагийн алба хаагчдын сургалтын эрэлт, хэрэгцээ, сахилга, ёс зүйн байдал, гадаадын улс орнуудын цагдаагийн байгууллагын сургалтын төлөвлөлт, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс ирүүлсэн санал, гэмт хэргийн тоон мэдээлэл, Цагдаагийн ерөнхий газрын бодлого, чиглэл зэргийг судлан үзсэний үндсэн дээр шаардлагатай сургалтын цаг, сэдэв, төрлийг тогтоож, алба хаагчдад чиглэгдсэн богино хугацааны сургалт зохион байгуулахаар төлөвлөж, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2015 оны “Сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2015 онд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны чиглэлээр мэргэшүүлэх 50, удирдах ажилтны 3, давтан болон албан тушаалын сургалт 20, ур чадвар ахиулах, хүний хөгжлийн 32 буюу нийт 105 удаагийн сургалт явагдаж, 4557 алба хаагч, 137 иргэнийг тус тус хамруулсан. Үүнээс удирдах ажилтан 118, ахлах албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчид 182, хэрэг бүртгэгч,

мөрдөн байцаагч, замын цагдаагийн байцаагч, хэсгийн байцаагч 2252, хэсгийн төлөөлөгч, эрүүгийн төлөөлөгч 340, ахлагч бүрэлдэхүүнээс 1660 алба хаагч хамрагдсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу цагдаагийн мэргэжлийн, “Шуурхай удирдлагын штаб”-ын дэргэдэх тусгайлсан чиг үүрэгтэй бүлгүүдийн сургалт, сургагч багш нарын заах арга зүй, ур чадварыг дээшлүүлэх, “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтарсан сургалт, удирдах ажилтаны сургалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны мэргэшүүлэх, давтан болон ур чадвар ахиулах, албаны нохойн туслах төлөөлөгчдийн давтан, галт зэвсгийн ур чадвар олгох, цагдаагийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, чиг хандлага, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, мэдээллийг хүлээн авах”, “Хэргийн газрын үзлэг, хойшлуулшгүй ажиллагаа явуулах нь”, “Гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа” зэрэг сэдвээр, мөн “Олон нийтийн цагдаагийн ажилтан, гэрээт харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх”, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Булган, Орхон, Дархан-уул, Өмнөговь, Говьсүмбэр зэрэг аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст “Байгууллагын болон хувийн аюулгүй байдлыг хангахад анхаарах асуудал”, “Нийтийн эмх замбараагүй байдлын үед ажиллах ажиллагаа” сэдвээр 16 цагийн, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй”, “Хүний хөгжил”-ийн чиглэлээр 8 цагийн, “Гэрээт харуул хамгаалалтын ажилтан” бэлтгэх 2 удаагийн, “Хар тамхи, тэсэрч дэлбэрэх бодис эрж хайх, илрүүлэх” сэдвээр 3 сарын бүсчилсэн сургалт тус тус зохион байгуулсан.

Цагдаагийн байгууллагын “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг 2015 оны 02 дугаар сарын 04-09-ны өдрүүдэд зохион байгуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 108 удирдах ажилтан оролцсон.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагуудын парламентын Ассамблейн хурлын үеийн цагдаагийн хамгаалалтын бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 132 дугаар тушаалаар Хууль сахиулахын Их сургуулийн төгсөлтийн дараах сургуулийн англи хэлний 1 сарын сургалтад 20 алба хаагчийг хамруулсан.

“Төгс бүсгүйчүүд” төрийн бус байгууллагатай хамтран ХДХВ, ДОХ-оос сэргийлэх тусламж үйлчилгээ, дэмжлэгийн үндэсний хөтөлбөрийг өргөжүүлэх замаар ХДХВ-ын халдварын тархалтын бага түвшинг тогтоон барих төслийн хүрээнд цагдаагийн байгууллагын ажилтнуудад нөлөөлөх нөлөөллийн уулзалтыг энэ оны 05 дугаар сарын 15-ны өдөр Нарантуул зочид буудалд зохион байгуулж, 20 алба хаагчийг хамруулсан.

“Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх сургалтын төлөвлөгөө”-ний дагуу “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил”, “Эргүүлийн үүрэг гүйцэтгэх”, “Захиргааны зөрчил ба шийтгэл”, “Олон нийтийн цагдаагийн ажилтнаас торгууль оногдуулах үндэслэл, журам”, “Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, сургалтад хамрагдсан 7 аймгийн 54 иргэнд олон нийтийн цагдаагийн ажилтны “Гэрчилгээ” олгосон.

“Дэлхийн Зөн-Монгол” олон улсын байгууллагатай хамтран Олон улсын хүүхдийн “Найрамдал” төвд “Удирдлагын манлайлал, ёс зүй” сэдвээр төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн тасаг, хэсгийн дарга нарыг хамруулсан сургалт зохион байгуулж, 45 удирдах ажилтныг хамрууллаа.

Цагдаагийн байгууллагад туршилтын хугацаагаар ажиллаж байгаа алба хаагчдын офицер албан тушаалын сургалтыг энэ оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд Хээрийн сургалтын хэсэгт зохион байгуулж, 17 алба хаагчийг төгсгөв.

Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч нарыг мэргэшүүлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Б/139 дүгээр тушаалаар Олон салбарын мэргэшсэн дотоод аудиторуудын хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, “Дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлэх нь” сэдэвт 2 өдрийн сургалтад тус газрын 6, Улаанбаатар хотын цагдаагийн газрын 1 алба хаагчийг хамруулан батламж олгуулсан.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орчиндоо түгшүүр төрүүлдэг, байнга архидан согтуурч гэр бүлдээ хүчирхийлэл, дарамт учруулдаг иргэдийн зан үйлийг өөрчлөх зорилгоор “Хүчирхийлэл үгүй гэр бүлд таны оролцоо” сэдэвт 6 цагийн сургалтыг Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн гуравдугаар хэлтэс, хорооны хамтарсан баг, дүүргийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран энэ оны 03 дугаар сарын 03, 19-ний өдрүүдэд зохион байгуулж, 180 иргэнийг хамруулсан байна.

Хууль зүйн яам, ХБНГУ-ын Хайнс Зайделийн сангийн Эрх зүйн боловсролын академиас хамтран Бавари мужийн Аугсбургийн Эрүүгийн цагдаагийн газрын дарга,

эрүүгийн албаны тэргүүн комиссар Клаус Байерлын энэ оны 04 дүгээр сарын 20-ны өдөр удирдан явуулсан ХБНГУ-ын эрүүгийн нөхцөл байдлын талаарх сургалтад алба хаагчдыг хамруулсан.

Хүний эрхийн үндэсний комисс хамтран 2015 онд Хууль сахиулах их сургуулийг "Цагдаагийн ажил-эрх зүй" мэргэжлээр төгссөн 200-н алба хаагчдад хүний эрхийн үндсэн ойлголт, хүний эрхийг хамгаалах, эрүүдэн шүүхийн эсрэг дотоодын хууль тогтоомж, хүний эрх, түүнд суурилсан хандлага, хүний эрхийн хязгаарлалт, хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын хүний эрхийн талаар баримтлах үндсэн хэм хэмжээ зэрэг агуулгаар сургалт явуулсан.

Хууль зүйн яам, Хууль сахиулахын их сургууль хамтран Улаанбаатар хотын цагдаагийн газар, түүний харьяа дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн зорилтот бүлэгт "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чадамжийг дээшлүүлэх" сэдэвт сургалтыг Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны төвд 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав. Сургалтад Улаанбаатар хотын цагдаагийн газар, дүүргүүд дэх цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хэсгийн байцаагчийн албан тушаалд ажиллаж байгаа 150 гаруй алба хаагчид хамрагдсан.

Гадаад харилцааны чиглэлээр: Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар – Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн ерөнхий газар хооронд Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх болон хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулсан.

Монгол Улсын Хууль зүйн яам, Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яам хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээрийг шинэчлүүлэхээр хэлэлцээрийн төслийг боловсруулан саналаа Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Эрүүгийн цагдаагийн газартай хамтран ажиллах "Харилцан ойлголцлын бичиг"-ийн төслийг боловсруулан ХБНГУ-ын талд хүргүүлсэн боловч айлын талаас санамж бичиг байгуулах шаардлагагүйгээр хэлэлцэж тохирсон 4 асуудлыг ажил хэрэг болгохоо илэрхийлсэн.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яам хооронд 1998 онд байгуулсан хамтын ажиллагааны хэлэлцээрийг шинэчлүүлэхээр төслийг боловсруулан Гадаад хэргийн яам, ХЗЯам болон БНХАУ-ын талд хүргүүлсэн.

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конг болон Макао-тай тус тус байгуулах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулан Хонг Конг, Макоогийн талд хүргүүлж ажилласан.

ОХУ-ын Буриад Улсын Дотоод хэргийн яамны урилгаар Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, тэргүүн дэд комиссар Ц.Батсүх тэргүүтэй төлөөлөгчид 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Буриад Улсын нийслэл Улаан-Үүд хотноо хоёр талын хамтарсан уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр харилцан зорчиж буй иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааг дээшлүүлэх талаар санал солилцож, хамтран ажиллах тодорхой чиглэлүүдийг харилцан тохиролцож, тэмдэглэлд гарын үсэг зурсан.

2015 онд цагдаагийн байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гадаад орны цагдаагийн байгууллагад 9 удаагийн айлчлалын арга хэмжээ зохион байгуулж, айлчлалын бүрэлдэхүүнд нийт 16 алба хаагчийг хамруулан дэмжлэг үзүүлсний зэрэгцээ гадаад улсад зохион байгуулагдсан нийт 12 удаагийн уулзалт, зөвлөгөөн, хурлын арга хэмжээнд 16 алба хаагчийг оролцуулсан ба гадаад оронд нийт 12 удаа 35 алба хаагч албан томилолтоор ажилласан, цагдаагийн байгууллагын 309 алба хаагчийг гадаад улсад зохион байгуулагдсан 31 сургалтад хамруулснаас урт хугацааны 2 сургалтад 3 алба хаагч, богино хугацааны буюу 3 сар хүртэл хугацааны 29 сургалтад давхардсан тоогоор 306 алба хаагчийг хамруулж, сургалт арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх илтгэх хуудсыг хүлээн авч ажилласан болно.

Мөн түүнчлэн Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, алба хаагчдыг сургах, харилцан туршлага солилцох, терроризмтэй тэмцэх чадавхийг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор 2015 оны 09 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод "Бүргэд-2015" хамтарсан дадлага, сургалтыг амжилттай зохион байгуулж, Монгол Улсын цагдаагийн байгууллагаас 128, БНХАУ-ын цагдаагийн байгууллагаас 583 алба хаагч, ажиглагчаар Монгол Улсын Үндэсний аюулгүй

байдлын зөвлөлийн ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хууль сахиулахын их сургуулийн төлөөлөгчид оролцсон.

Монгол Улсын нийслэлд 2015-2016 онд зохион байгуулагдах олон улсын томоохон арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, туслах комиссар П.Энхтогтох Ази-Европын Дээд түвшний уулзалт /ASEM/-ын аюулгүй байдлыг хангах асуудлаар туршлага судлах зорилгоор 2015 оны 03 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд Итали Улсад, 2015 оны 06 дугаар сарын 12-ноос 19-ний өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад, 2015 оны 12 дугаар сарын 06-наас 12-ны өдрүүдэд Сингапур Улсын Дотоод хэргийн академиас зохион байгуулсан сургалтад томилолтоор ажиллаж АСЕМ-ын хурлын хамгаалалтыг зохион байгуулах ажлын хүрээнд аюулгүй байдлыг хангах чиглэлээр туршлага судлах зорилгоор үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалтын газрын дарга Нам Жү Сунг-ийн 2015 оны 04 дүгээр сарын 20-ноос 23-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулсан.

Мөн Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингисийн урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засаг захиргааны дэд тэргүүлэгч, Нийгмийг аюулаас хамгаалах танхимийн дарга, цагдаагийн дэслэгч генерал Ма Мин тэргүүтэй 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийн 2015 оны 12 дугаар сарын 14-нөөс 18-ний өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалыг зохион байгуулсан ба айлчлалын үеэр тус тэнхимээс Монгол Улсын цагдаагийн байгууллагад 1 000 000 /нэг сая/ юаны үнэ бүхий хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх багаж 3 ширхэг, сансрын холбооны аппарат 6 ширхэг зэрэг тусгай зориулалтын техник хэрэгслэл албан хэрэгцээнд зориулан бэлэглэсэн болно.

Хууль зүйн сайдын 2015 оны А/47 дугаар тушаалын дагуу ОХУ-ын Сибир дэх хуулийн институтэд хар тамхи, мансууруулах бодисын чиглэлээр 2015-2016 оны хичээлийн жилд суралцах сонсогч нарыг сонгон шалгаруулах, элсүүлэх ажлыг зохион байгуулж, сонгон шалгаруулалтад Хууль сахиулахын их сургуулийн 24 сонсогч бүртгүүлснээс 5 сонсогч шалгарсан.

Мэргэжил, хяналтын чиглэлээр: Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх авто сургуулиудаас Улаанбаатар хотын 3713, орон нутгийн 4031 элсэлтийн тушаалыг бүртгэлд оруулан баталгаажуулж, 6762 авто сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Бүртгэгдсэн 100612 иргэн замын хөдөлгөөний хууль, дүрэм, жолоодлогын шалгалтад хамрагдсанаас 58.8 хувь буюу 58106 иргэн шалгалтад тэнцэж жолооч болсон байна.

Жолооны ангилал дээшлүүлэх хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч, шинээр В ангиллын 57156, ВС ангиллын 2043, механизмын 1126, мотоциклын 4496, гадаадын 1734 иргэнд үнэмлэх шинээр олгож, солих буюу нөхөж олгох шаардлагатай 64431 жолооны үнэмлэхийг дахин олгож, В-ВС ангилалд 9533, ВС-BCD ангилалд 5405, ВС-ВСЕ ангилалд 2716, ВС-BCDE ангилалд 882 иргэний ангиллыг ахиулж, нийт 174824 үнэмлэх хэвлэж олгосон.

Улсын хэмжээнд жолооны эрх нь хасагдсан 37081 иргэний мэдээллийг санд оруулж, эрх сэргээх шалгалтад тэнцсэн 73126 иргэний жолооны эрхийг сэргээж, холбогдох материалыг санд орууллаа.

Тээврийн хэрэгслийн жолоочийн үнэмлэхээ үрэгдүүлсэн, солиулахаар хандсан иргэдээс зөрчилтэй 591 иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдуулсан 23.269.000 төгрөгийн торгууль төлөөгүй байсныг нөхөн төлөлт хийсний дараа үйлчилгээ үзүүлэхээр буцааж, үйлчилгээний танхимаар 181953 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

Зөвшөөрөл, хяналтын чиглэлээр: Монгол Улсын хилээр галт зэвсэг оруулах хүсэлт гаргасан 305 иргэн, 38 спорт, буудлагын холбоод, ан агнах 107 гадаадын иргэн, галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 320 иргэнд зөвшөөрөл олгосон.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлох, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл хүссэн 47, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут, чиглэл батлуулах хүсэлт гаргасан 678, тэсрэх бодис болон овор ихтэй ачаа тээвэрлэх зөвшөөрөл хүссэн 60 аж ахуйн нэгж, байгууллагын 126 тээврийн хэрэгслийн материалыг хянаж, 46 аж ахуйн нэгж, байгууллагын 99 тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийг олгосон.

Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-ын дагуу 595 байгууллага, албан

тушаалтанд харьяалагдах 1527 тээврийн хэрэгслийн материалыг хүлээн авч хянан 551 байгууллага, албан тушаалтны 1463 тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх зөвшөөрлийг олгосон.

Уг журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн хэмжээнд 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай “Тусгай дуут болон гэрэл дохио” сэдэвт нэгдсэн арга хэмжээг зохион явуулж, Хан-Уул, Баянгол дүүрэг дэх Замын цагдаагийн тасгуудтай хамтран 2 удаа хяналт шалгалт хийж, ажлын дүн мэдээг нэгтгэн ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах газрын дарга болон төвийн даргад танилцуулсан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Нийслэлд зөвшөөрөлгүй тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэж явсан 83 зөрчил илрүүлж, 22 тусгай дуут болон гэрэл дохиог тээврийн хэрэгслийн гэрчилгээний хамт хураан авч, холбогдох хууль тогтоомжийн дагуу 240.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Төвийн даргын баталсан хуваарийн дагуу 7 хоног бүрийн Лхагва гарагт тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэж байгаа тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулах зорилгоор гудамж, замд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан 4 байгууллагад 200.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж, 1 тээврийн хэрэгслийг /тээврийн хэрэгсэл/ түр саатуулах байранд хийж, 17 аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт явуулж, 14 зөрчил илрүүлж, бичиг баримтыг түр хураан, 25 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх талаар сургалт, зөвлөгөө өгч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга нарын хамтарсан 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/321, 231 дүгээр тушаалаар “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ыг батлуулсан.

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай, зардал багатай хүргэх “Цахим болон мобайл технологид суурилсан програм хангамжийн нэгдсэн үйлчилгээний портал систем хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвөөс үзүүлж буй тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох, жолоодох эрх сэргээх, үнэмлэх нөхөн олгох, жолоочийн үнэмлэх солих, гадаадын иргэнд жолооны үнэмлэх сольж олгох, жолоочийн лавлагаа гэсэн 6 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, Мэдээлэл, технологийн паркад 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулан, иргэд ТҮЦ машинаас төрийн үйлчилгээнд нэвтрэх түлхүүр үг авч www.ezasag.mn сайтаар дээрх үйлчилгээнүүдийг бүрэн авах боломжтой болсон.

Мөн дээрх төслийн хүрээнд иргэдэд олгодог тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа, жолоочийн зурагтай лавлагааг Төрийн үйлчилгээний цахим машинаас авах боломжийг бүрдүүлж, 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс иргэдэд олгох үйлчилгээг нэвтрүүлээд байна.

Архивын үйл ажиллагааны чиглэлээр: 2015 онд архивын баримтаас лавлагаа, хуулбар авахаар 80 байгууллага, 1027 иргэний захиалгыг хүлээн авч шуурхай үйлчилж ажилласан.

Нийт 1540 алба хаагч, иргэнд лавлагаа олгож, 1516 хуудас архивын баримтыг хуулбарлан олгосон байна. Архивын лавлагаа хуулбар гаргахдаа архивчид хадгаламжийн сангаас 7778 хадгаламжийн нэгж, 711 боловсон хүчний хувийн хэрэг, Цагдаагийн ерөнхий газрын хүний нөөц, сургалтын хэлтсээс 400 боловсон хүчний хувийн хэргийг татан авч шүүлт хийж ашигласан байна. Түүх судлалын секторын судлаач нар цагдаагийн байгууллагуудын холбогдолтой баримтыг судлахад хадгаламжийн сангаас 350 хадгаламжийн нэгжийг авч ашигласан. Тусгай сангийн архивч нар дотоодын хэрэгцээндээ 192 хадгаламжийн нэгжийг авч, ашиглаж шүүлт хийсэн байна. Хадгаламжийн санд хадгалагдаж байгаа баримтаас дотоодын хэрэгцээнд 9031 хадгаламжийн нэгжийг архивч, судлаач нар дотоод хэрэгцээндээ лавлагаа хуулбар гаргах холбогдох баримтыг судлахад авч ашиглажээ.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 314 дүгээр тогтоолын биелэлтийг хангах зорилгоор АЕГ-тай байгуулсан гэрээний дагуу 4 гэрээт- архивч операторыг томилон ажиллуулж, хадгаламжийн санд хадгалагдаж байгаа 81 хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтаас цахим хэлбэрт оруулахаар скайнердсан 43 хөмрөг, түүнээс Photoshop программаар засварласан 11 хөмрөгийн 213 хадгаламжийн нэгжийн 94518 хуудас тушаалыг засварласан байна. Үүнээс AMS програмд нийт 39 хөмрөгийн 1091 хадгаламжийн нэгжийн 178733 хуудас тушаалыг цахим хэлбэрт шивж оруулсан. Цаасан

сууртай баримтыг цахим хэлбэрт оруулж байгаа мэдээг АЕГ-ын мэдээлэл, үйлчилгээний удирдлагын газарт сар бүр өгч, удирдамж чиглэл авч ажилласан.

2015 оны нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу Орхон аймгийн Дотоодын цэргийн 816 дугаар ангийн түр хадгалах 286 хадгаламжийн нэгж, байнга хадгалах 30 хадгаламжийн нэгж, Орхон аймаг Эрдэнэт хотын цагдаагийн газрын байнга хадгалах 48 хадгаламжийн нэгж, Булган аймаг дахь цагдаагийн газрын 81, Төмөр зам дахь цагдаагийн хэлтсийн 26, Улаанбаатар хотын цагдаагийн газрын байнга хадгалах 190 хадгаламжийн нэгж, мөн газрын боловсон хүчний 139, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын 107, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын боловсон хүчний 3 хадгаламжийн нэгж, Завхан аймаг дахь цагдаагийн газрын боловсон хүчний 50 хадгаламжийн нэгж, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын боловсон хүчний 10 хадгаламжийн нэгж, Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын боловсон хүчний 3 хадгаламжийн нэгж, Говьсүмбэр аймгийн цагдаагийн газрын байнга хадгалах 37 хадгаламжийн нэгж, Цагдаагийн ерөнхий газрын боловсон хүчний 355 хадгаламжийн нэгж, Архангай аймгийн цагдаагийн газрын байнга хадгалах 92 хадгаламжийн нэгж, Төв аймаг дахь цагдаагийн газрын 87, нийт 1243 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, нягтлан шалгаж, бүртгэлийн дугаар олгон санд байршуулсан.

Монгол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2007оны 28/147/115 дугаар тушаалаар баталсан “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын төрөлжсөн архивын ажлын заавар”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв архивын газрын санд хадгалагдаж буй Хөвсгөл, Өмнөговь аймгуудын цагдаагийн газарт хадгалагдаж байх ёстой 1446 хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийг ялган ангилалт хийсэн.

ЦЕГ-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлыг 3 удаа хуралдуулж, нийт 241 асуудал хэлэлцүүлж, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт 1, байнга хадгалах баримтын бүртгэл 89, түр хадгалах баримтын бүртгэл 27, устгах бичгийн жагсаалт 7, захиргааны зөрчлийн устгах хэргийн акт 22, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын явцад хэрэгсэхгүй болгосон устгах хэргийн акт 24, хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын шатанд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан материалын устгах хэргийн акт 17, мэдээлэл, технологийн төвийн 10 нэр төрлийн 483377 хуудас гэмт хэргийн маягт, “хүч” албаны спорт сургалтын хэлтсийн 174 баримт, хэрэг бүртгэх хэлтсийн 500 баримт, захиргааны зөрчлийн 11426 хэргийн материалыг устгах хэргийн бүртгэл, хадгаламжийн хугацаа дууссан түүх, эрдэм шинжилгээний болон практик ач холбогдолгүй болсон 1220 албан хэргийн устгах акт бүртгэлийг баталж, устгах талаар чиглэл өгч, биелэлтийг нь хянаж ажилласан.

Цагдаагийн музейд хадгалагдаж буй сан хөмрөгийг баяжуулах зорилгоор үе үеийн цагдаагийн байгууллагын дарга нарын түүх намтар, эдэлж хэрэглэж байсан эд, зүйлийг олох ажлыг гэр бүл, үр хүүхдүүдтэй нь хамтран зохион байгуулж, Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив, Батлан хамгаалахын архив, бусад архивын сан хөмрөгтэй танилцан судалгаа хийж, хамтран ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үе үеийн цолны мөрдөс, тэмдгийг он цагийн дараалалд оруулан тусгайлан жаазалж үзмэр болгосон. Тайлангийн хугацаанд цагдаагийн музейг 1852 иргэн үзэж сонирхсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны А/62 дугаар тушаалаар батлагдсан загварын дагуу байгууллагын архивын ажлын үндсэн заавар болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан төв, орон нутгийн цагдаагийн 40 байгууллагад анхан шатны архивын “Гэрчилгээ” олгосон.

Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудын ажлын идэвх, санаачлага, хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор шагналын журмыг боловсруулж, “Шагнал, урамшил олгох” /код-925/ -журамд тусгуулж ЦЕГ-ын даргын 2015 оны А/79 дүгээр тугаалаар батлуулан мөрдүүлж байна. 2015 оны “Он цагийн түүхийн гэрч”-ээр тусгай сангийн эрхлэгч цагдаагийн хошууч Т.Оюунзулыг шалгаруулан шагнасан.

Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар: “Жагсаал, цуглааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид анхаарах зарим асуудал”, “Алба хаагчдын албандаа хандах хандлага, түүнийг дээшлүүлэх арга зам”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг алба хаагч, иргэдийн дунд сурталчлах”, “Цагдаагийн байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлэх”, “Гар аргаар алт олборлох гэмт хэргийн нөхцөл байдал”, “Мөрдөн байцаагчийн мэдэгдэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэрхэн нөлөөлж буй байдал”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай шинэ хууль хэрэгжсэнээр үүсэх эерэг болон сөрөг талууд”, Төв аймгийн Сэргэлэн сумын “Хөшигийн хөндий” хэмээх газар баригдаж буй шинэ нисэх онгоцны буудал барих ажлын хэсгийн

цуглуулсан материалд, “Цагдаагийн алба хаагчийн харилцааны соёл”-ын талаар, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу сүүлийн 5 жилд түдгэлзүүлсэн хэргийн судалгаа зэрэг нийт 36 судалгаа, дүн шинжилгээ хийн, танилцуулга бичиж, цаашид авч хэрэгжүүлэх ажлыг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүүхдээс үйлдэж буй нийтлэг тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор сүүлийн 10 жилийн судалгаа, Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн талаарх судалгааг сүүлийн 3 жилээр, Зам тээврийн осол, хэрэг, зөрчлийн талаарх сүүлийн 10 болон 5 жилийн байдлаар статистик судалгааг гаргаж шаардлагатай судалгаа, дүн шинжилгээний ажилд ашиглаж байна.

Цагдаагийн алба хаагчдын албандаа хандах хандлагыг тодорхойлох бичил судалгааг Улаанбаатар цагдаагийн хүрээний газар, хэлтсийн 115 алба хаагчийн дунд социологийн, 15 алба хаагчтай ярилцлагын аргаар судалгаа, “Цагдаагийн албаны шинэчлэлийн үр дүнгийн талаар судалгаа”, “Хүний амь нас хохирсон гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох судалгаа”, “Зан үйл судлалын үндэсний төв” ТББ-тай хамтран Нийслэлийн 11 дүүргийн 200 алба хаагчийн дунд “Нийгмийн оюун ухааныг судлах” судалгааг тус тус хийж үйл ажиллагаанд ашиглаж байна.

Улаанбаатар хот болон Төв аймаг дахь цагдаагийн газарт орчин үеийн шаардлага хангасан байцаалтын өрөөг тохижуулах талаар, “100.000 хүн ам тутамд ногдох гэмт хэргийн судалгаа-гэмт хэргийн өсөлт бууралтыг хүн амын өсөлттэй уялдуулан тооцох аргачлал”-ын талаар, “Хөршийн хяналт-олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааны журам, ажлын төлөвлөгөө” зэргийг судлан санал боловсруулсан.

Эрүүгийн хууль батлагдсантай холбогдуулан цагдаагийн байгууллагад үүсэх ачаалал, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээний талаар мэдээлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны уламжлал, шинэчлэл сэдэвт танилцуулга зэргийг боловсруулж ЦЕГ-ын тэргүүн дэд даргад танилцуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөл”-өөс өгөгдсөн үүргийн дагуу “Мал хулгайлах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” ажлын үр дүнд судалгаа, дүн шинжилгээ хийсэн тайланг Мөрдөн байцаах газарт хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/81 тоот тушаалаар “Цагдаагийн байгууллагын соёлын журам боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх, цаашид хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төсөвлөж танилцуулах судалгаа хийгдэж байна.

“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар цагдаагийн байгууллагаас хүлээсэн үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдал”-д хийсэн дүн шинжилгээний тайлан болон “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” багц хичээлийн хөтөлбөр зэргийг боловсруулсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:Цагдаагийн байгууллагын хэмжээнд 4185 алба хаагчийн 2014 онд мэдүүлсэн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч нэгтгэн, тайланг хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагад анх орох болон албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 418 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэгт дүгнэлт гаргуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хариуг авсан.

Цагдаагийн байгууллагын авлига, хүнд суртал болон ашиг сонирхолын зөрчил үүсч болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах албан хаагчдын авлигын хандлагыг тодорхойлох зорилгоор Авлигатай тэмцэх газраас 2014 онд хийсэн судалгааны дүнг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлсэн.

Алба хаагчдаас 2014 онд мэдүүлсэн “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг үнэн зөв мэдүүлсэн эсэхийг хянах ажлыг үе шаттай зохион байгуулсан.

ХАСХОМ-д хяналт тавих бэлтгэл ажлын хүрээнд Цагдаагийн байгууллагын хэмжээнд тасгийн даргаас дээш албан тушаалд ажиллаж буй алба хаагчдын болон гэр бүлийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг түүвэрлэж, нийт 1688 хүний лавлагаа авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын Гадаадын хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн бүртгэлийн газар, Эд хөрөнгийн бүртгэл, цахимжуулалтын газар, Авто тээврийн үндэсний төвд албан бичгээр хүсэлт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн бүртгэл цахимжуулалтын газраас лавлагаагаар цагдаагийн 402 алба хаагчийн нэр дээр үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ гаргасны дагуу ХАСХОМ-ийн цахим санд шивэгдсэн 125 алба хаагчийн нэр дээр бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийг нэг бүрчлэн тулгалт хийж, үл хөдлөх хөрөнгөө мэдүүлээгүй 55, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Гадаадын хөрөнгө оруулалт, хуулийн этгээдийн бүртгэлийн газрын лавлагаагаар 76 хүний нэр дээр бүртгэл гарсныг ХАСХОМ-ын цахим сантай тулгалт хийж, санд мэдүүлээгүй 30 зөрчлийг тус тус илрүүлсэн. Мөн Авто тээврийн үндэсний төвийн лавлагаагаар 157 алба хаагчийн нэр дээр 161 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй гарсны дагуу ХАСХОМ-ын цахим санд тулгалт хийж, 81 алба хаагч тээврийн хэрэгслээ мэдүүлээгүй байгаа зөрчлийг илрүүлэн засуулах арга хэмжээг авч ажилласан.

Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг алба хаагчдад сурталчилах зорилгоор “Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг ажил амьдралдаа хэрэгжүүлцгээе” богино хэмжээний 12 ангит кино хийх санхүүжилтийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/244 дүгээр тушаалаар шийдвэрлүүлж, ажлын гүйцэтгэгчээр Идуган Энтертаймент ХХК-ийг шалгаруулсан.

Идуган Энтертаймент ХХК-ий захирал, Монгол Улсын Ардын жүжигчин А.Энхтайвантай байгуулсан гэрээний дагуу “Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг ажил амьдралдаа хэрэгжүүлцгээе” нэртэй богино хэмжээний 12 ангит кино бүтээсэн.

Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 122 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсыг 38 үзүүлэлтээр үнэлж, дүнг Авлигатай тэмцэх газар хүргүүлсэн.

Авлигатай тэмцэх газраас 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийн арга хэмжээний үеэр Цагдаагийн ерөнхий газрыг “Ил тод нээлттэй цахим хуудастай байгууллага” номинацаар шалгаруулж, “Шудрага ёсны төлөө 2015” өргөмжлөлөөр шагнагдсан.

*Тав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний
ажлын талаар:*

2016 оны төсөв, 2017-2018 оны төсвийн төсөөллийг харъяа байгууллагаас авч нэгтгэн, 2016 оны төсвийн төслийг 260,0 тэрбум төгрөгөөр боловсруулан 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдөр Санхүү, хангамжийн газрын даргын 9/858 тоот албан бичгээр Хууль зүйн сайдад хүргүүлсэн. Үүнийг Сангийн яам 142,9 тэрбумаар хянасан боловч Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Улсын их хуралд 129,0 тэрбум төгрөгийн төсөв өргөн барьсан нь хянасан төсвөөс 13,9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ талаар танилцуулга, мэдээллийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулсны үр дүнд 2016 оны төсвийг 146,2 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэн батлуулсан.

Цагдаагийн байгууллагын 2015 оны батлагдсан төсөвд дутагдаж буй цалингийн зардалд 3.0 тэрбум төгрөг, Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэрт гарсан алба хаагчдад олгох 1.4 тэрбум төгрөгийг нэмүүлэх саналаа Хууль зүйн сайдад 2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 1/356 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнээс цалингийн зардалд 1.7 тэрбум, ажил олгогчоос төлөх эрүүл мэндийн даатгалд 42.5 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газар нь 2015 оны 12 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 127,0 тэрбум төгрөгийн төвлөрсөн санхүүжилт, 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлого болох гэрээт, эрүүлжүүлэх, баривчлах, журмын хашаа, хэвлэхийн орлогоор 7,6 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилтээр 121,0 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 9,1 тэрбум төгрөг оруулахаас 7,6 тэрбум төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 17 хувиар буюу 1,5 тэрбум төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Монгол Улсын Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын вэб хуудасны “Ил тод байдал” булангийн “Үйл ажиллагааны ил тод байдал хэсэг”-т “Шилэн данс” нэр бүхий дэд

хэсэг үүсгэн, Сангийн яамнаас хэрэгжүүлэн ажиллуулж, Шилэн дансны цахим хуудас /shilendans.gov.mn/-тай холбосон.

Цагдаагийн байгууллагын 2014 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн худалдан авах ажиллагааны тайланг www.police.gov.mn вэб сайтын шилэн дансанд, мөн цагдаагийн байгууллагын 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.pmmis.mof.gov.mn вэб сайт болон www.police.gov.mn вэб сайтын шилэн дансны хөрөнгө оруулалтын мэдээлэлд байршуулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд 2 тэрбум төгрөгөөр кобаны барилгыг нэг бүр нь 80 000 000 /наян сая/ төгрөгийн өртөг бүхий 18 x 8 метр хэмжээтэй 144м² талбай бүхий барилгыг Архангай аймгийн Цэцэрлэг, Цахир, Баян-Өлгийн аймгийн Бугат, Сагсай, Баянхонгор аймгийн Галуут, Баянбулаг, Булган аймгийн Бүрэгхангай, Гурванбулаг, Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалан, Дундговь аймгийн Дэрэн, Баянжаргалан, Завхан аймгийн Түдэвтэй, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Богд, Зүүнбаян-Улаан, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Төв аймгийн Заамар, Баяндэлгэр, Хөвсгөл аймгийн Түнхэл, Тосонцэнгэл, Ховд аймгийн Жаргалант зэрэг нийт 13 аймгийн 25 сумдад бариулж, Улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад авснаар орон нутгийн цагдаагийн газрын цагдаагийн алба хаагч нарыг ая тухтай орчинд ажиллуулах боломжоор хангасан.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн гуравдугаар хэлтсийн байр барих 1.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/05 дугаар захирамжаар Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт 2059 м² газар эзэмших гэрчилгээ гаргуулсан.

Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Баянгол дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн шинэ байрыг 1.9 тэрбум төгрөгөөр барьж, 2015 оны 10 дугаар сарын 17-ны өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.

Нийслэлийн засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 09-ний А/22 тоот “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжих барилгын хүрээнд нийслэлийн Засаг даргаас Чингэлтэй дүүргийн засаг дарга Д.Ганболдод худалдан авах ажиллагааны эрх шилжүүлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн барилгын их засварын ажилд 300.0 сая төгрөг төсөвлөгдөж, 243.5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын цагдаагийн газрын харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн албан хэрэгцээнд автомашин нийлүүлэгчээр шалгарсан “Монгол хьондай автомотив” ХХК-иас нийт 956.0 сая төгрөгийн өртөг бүхий цагдаагийн дуут гэрлэн дохио, холбооны станц, камераар тоноглогдсон 27 “Хьондай элентра” маркийн автомашин, Төрийн өмчийн хорооны 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 1а/2955 дугаар тогтоолоор албанд хэрэглэж байсан 13 автомашиныг хүлээн авсан.

2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн болон аймаг сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хамгаалалтын зардлын тооцоог гарган, 2016 оны төсвийн төсөлд тусгуулах саналыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Арван долдугаар жарны “Хөхөгчин” хонин жилийн сар шинийн баярыг тохиолдуулан харьяа газар, хэлтсийн 674 ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 19.5 сая төгрөг зарцуулсан.

Улсын төсвийн 2015 оны хөрөнгө оруулалтаар цагдаагийн байгууллагын тусгай техник хэрэгслийн зардалд 1,197 сая төгрөг батлагдсаны дагуу БНЧУ-ын “Банзай” ХХК-тай 96,0 сая төгрөгийн 4 нэр төрлийн 171,720 ширхэг галт хэрэглэлийн гэрээ байгуулж, хийн гар буу 365, хийн сум 10,000 ширхэгийг тус худалдан авсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 122, 2013 оны 309 дүгээр тогтоол, Хууль зүйн сайдын төсвийн багцын хүрээнд 2015 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг үндэслэн цагдаагийн алба хаагчдад 3,6 тэрбум төгрөгөөр 46 нэр төрлийн дүрэмт хувцасны даавуу, туслах материал бэлтгэн нийлүүлэх нээлттэй шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан.

Цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, тусгай зориулалтын материалыг бэлтгэх гүйцэтгэгч шалгаруулахаар дотоодын 25, гадаадын 12 компани аж ахуй нэгжүүдээс санал ирүүлснээс, үнэлгээний хорооны 1, 2, 3, 4 дүгээр зөвлөмжөөр гүйцэтгэгч компаниар шалгарсан дотоодын 14 компанитай 32 нэр төрлийн 1,578,222,100 төгрөг, гадаадын 10

компанитай 37 нэр төрлийн 1,516,293,882 төгрөг, нийт 3,094,515,982 төгрөгний дүрэмт хувцас, материал хэрэглэл бэлтгэх гэрээ хэлцлийг байгуулсан.

Гэрээний дагуу бараагаа нийлүүлсэн болон гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу 2,4 тэрбум төгрөгийг барааны төлбөрт шилжүүлсэн. Хангалт йлчилгээний төвийн агуулахад 1,5 тэрбум төгрөгийн барааг татан авч бэлтгэж, 2015 онд хувцас хэрэглэл бэлтгэхээр батлагдсан төсвөөс 393 сая төгрөгийн хэмнэлттэйгээр гэрээ байгуулан ажилласан.

Цагдаагийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд ТОСК-той хамтран ажиллах гэрээг байгуулж, Буянт-Ухаа-2 орон сууцны хороололоос 100 квот хувиарлагдсанаас ТОСК-ын орон сууц захиалах, худалдан борлуулах шаардлага хангасан төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 73 алба хаагчдад хувиар олгож захиалгын гэрээ байгуулсан. мөн СБД-ийн 1-р хорооны Замын цагдаагийн газрын хойно баригдсан цагдаагийн алба хаагчдын 96 айлын орон сууц, Баянгол дүүргийн 3 дугаар хороо Автобаазын урд байрлах цагдаагийн алба хаагчдын 308 айлын орон сууцны барилгуудыг тус тус ашиглалтад оруулж, нийт 404 алба хаагчдыг чанартай, хямд өртөгтэй орон сууцаар хангах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан.

“Сүүж-уул” сэргээн засах сувиллын салбарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны нутаг дэвсгэрт байгуулж, амралтын үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн хорооны 249 дүгээр тогтоолоор цагдаагийн алба хаагчдын “Сүүж уул” сэргээн засах сувиллын үндсэн хөрөнгийн бүртгэлд авч, хаан банкны санхүүжилтээр 8х8 хэмжээтэй 2 давхар 2 ширхэг модон эко /дээд зэрэглэлийн/ байшинг бариулах барилгын ажлыг гүйцэтгүүлж, алба хаагчдыг байгалийн сайханд, ая тухтай орчинд амраахаар бэлтгэл ажлыг хангасан.

Төв, орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн өвөлжилтийн бэлтгэл ажлын явц байдалд хяналт тавьж Хамгаалалтын хоёрдугаар газар, Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Мөрдөн байцаах газар зэрэг зарим байгууллагын засварын ажилтай газар дээр нь танилцаж, зааварчлага чиглэл өгч ажилласан ба өвөлжилтийн бэлтгэл ажлын дүн мэдээг нэгтгэн дүгнэсэн.

Үндэсний их баяр наадам, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын парламентын ассамблей болон бусад олон нийтийн арга хэмжээний хэв журам, аюулгүй байдлын хамгаалалтад ажилласан цагдаагийн алба хаагчдад хүнсээр үйлчлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Зургаа. Дүгнэлт, зорилт:

Цагдаагийн байгууллага 2015 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ зохих ёсоор биелүүлэн ажилласан.

Цаашид цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө, эрх зүйн акт болон “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын ил тод байдал, дотоод хяналт, сургалтын арга хэлбэрийг сайжруулах бодлого баримтлан ажиллана.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР